



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 07/47

Булган


Г 7  
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх  
тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52.1.4, 52.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлж, суманд тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг оновчтой зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлсэн аж ахуйг шинээр байгуулж, үйлдвэрлэлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2024 он хүртэл жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан жагсаалтын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжиж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Идэрмөнх)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА *М. Дорноо* Ж.ДОЛООН-ОД

0721025

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
ээлжит 07 дугаар хуралдааны 2022 оны  
03 дугаар сарын 30-ны өдрийн 07/47  
дугаар тогтоолын хавсралт



БАЯН-ӨНДӨР СУМАНД 2024 ОН ХҮРТЭЛ ЖИЖИГ ДУНД  
ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТЭРГҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛИЙН ЖАГСААЛТ

2022 оын 03 дугаар сарын 30

Булган

1. Газар тариалан, Жимс жимсгэний аж ахуй, малын тэжээлийн ургамал
2. Малын гаралтай түүхий эд, арьс, нэхийгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх
3. Ахуйн үйлчилгээ, оёдол, гутал үйлдвэрлэл
4. Сүү цагаан идээ боловсруулах, сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаяг, шошго, сав баглаа боодол
5. Мал эмнэлэг
6. Орон нутгийн онцлог бэлгийн багц
7. Орчин үеийн тоног төхөөрөмжид суурилсан стандартад нийцсэн авто засвар, оношилгоо, угаалга

-----oOo-----